



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 19

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, сэлбэг хэрэгслээр ашиглах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй фургон маркийн автомашиныг сэлбэг хэрэгслээр ашиглан акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сум дундын ойн ангийн дарга (П.Уртнасан)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө акталснаас гарсан материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
19 тогтоолын хавсралт

Сум дундын ойн ангийн актлаж, сэлбэг хэрэгслээр ашиглах хөрөнгийн мэдээлэл



Д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэр-лэсэн он	Ашиглал-танд орсон огноо	Тээврийн хэрэгслийн мэдээлэл			Балансын үнэ	Хуримт-лагдсан элэгдэл	Үлдэг дэл өртөг
			сери	дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн			
1	УАЗ Пургон автомашин	220692-033	ДУА	73-48	2013	9/18/2013	37410D0413306	D0002536	2890	25,000,000	25,000,000	0
Нийт дүн										25,000,000 (хорин таван сая) төгрөг	25,000,000 (хорин таван сая) төгрөг	